

МОНГОЛЫН 1990 ОНЫ АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН ТАЛААРХ САНАЛ АСУУЛГЫН ДҮНГЭЭС

М.Шолпан

ХААИС, Байгалийн ухааны сургууль, Нийгмийн ухааны тэнхим

Өгүүллийн товч утга: 1980-аад оны II хагасаас ЗХУ-д өрнөсөн “Перестройка”-гийн үзэл санааны дагуу монголчуудын нийгэм, улс төрийн идэвх сэргэж, ялангуяа хөрш зэргэлдээ орнууд болоод улс орондоо ямар үйл явц болж байгааг сонирхон мэдэх гэсэн хүсэл эрмэлзэл эрс өсч, улмаар 1990 онд ардчилсан хувьсгал ялсан. Энэхүү танилцуулан буй материал 30-аас дээш насныхны дунд явуулсан санал асуултад тулгуурласан болно. Нэг үгээр, Монголын 1990 оны Ардчилсан хувьсгалын талаар ард олны санаа бодлыг судалж, дүгнэхийг оролдсон юм.

Түлхүүр үг: Хувьсгал, “Перестройка”

Монголын ард түмний нийгэм, улс төрийн идэвхийг өрнүүлж, ардчилал, ил тод байдлыг гүнзгийрүүлсэн Монголын Ардчилсан хувьсгал ялснаас хойш даруй 19 жил өнгөрөөд байна.

Монголын 1990 оны Ардчилсан хувьсгалын талаар иргэд, олон нийтийн санаа бодлыг судалж, дүгнэх гэсэн зорилготойгоор энэхүү асуулгыг 2009 оны нэгдүгээр сард хийсэн юм. Уг санал асуулга хоёр хэсэгтэй, хэсэг тус бүр зургаа, арван хоёр асуулттай байхаар зохиогдсон. Үүнд нийт 208 хүн хамрагдсан бөгөөд тэд Улаанбаатар хотын нийт хүн ам /1031,2→2007 оны тоо/-ын 20,17%-ийг эзэлж байна.

Санал асуулгад хамрагдагчдын 62,5% нь 30-40 хүртэл насны, 21,15% нь 41-50 хүртэл насны, 10,09% нь 51-60 хүртэл насны, 4,80% нь 61-70 хүртэл насны, 1,44% нь 71-ээс дээш насныхан байсан. Тэдний 106 нь буюу 50,96% нь эмэгтэй, 102 нь буюу 49,03% нь эрэгтэй хүмүүс байсны 65,86% нь дээд, 14,42% нь тусгай дунд, 19,23% нь бүрэн дунд боловсролтой гэж хариулсан. Харин 0,48% нь тодорхой шатны албан ёсны боловсрол олгох сургалтад хамрагдаагүй байна.

Асуулгад хамрагдагчдыг мэргэжил болон ажилладаг салбараар нь авч үзвэл 25,48% нь багш, 12,5% нь эдийн засагч, 10,57% нь хуульч, 8,65% нь инженер, 1,92% нь улс төрч, 2,40% нь химич, 2,88% нь түүхч, 35,57% нь бусад мэргэжилтэй хүмүүс, 66 буюу 31,73% нь боловсролын, 7 буюу 3,36% нь эрүүл мэндийн, 19 буюу 9,13% нь эдийн засгийн, 9 буюу 4,32% нь ХАА-н, 29 буюу 13,94% нь хувийн хэвшлийн, 32 буюу 15,38% нь бусад салбарт, 38 буюу 18,26% нь төрийн албад тус тус ажилладаг, 8 буюу 3,84% нь гэртээ байдаг гэсэн байна.

1990 оны Цагаан морин жил Монголд ардчилсан хувьсгал өрнөснөөр нийгмийн ардчилсан тогтолцоог бэхжүүлэх үйл явц өнөөг хүртэл үргэлжилж, 19 жилийг үджээ. Өнөөдөр энэхүү үйл явцыг эргэцүүлэн бодоход Таны хувьд юу байсан гэж дүгнэдэг вэ? гэсэн асуултад тэдний 48,55% нь ардчилсан хувьсгал байсан, 14,90% нь төрийн эргэлтийн шинжтэй үйл явц байсан, 12,5% нь МАХН болон шинээр гарч ирж буй залуу хүчнүүдийн хооронд бий болсон эрх мэдлийн төлөөх тэмцэл байсан, 11,05% нь хариулж мэдэхгүй байна, 9,13% нь тухайн үеийн төрийн удирдлагуудыг огцруулах зорилготой үйл явц байсан, үлдсэн хувь нь бусад гэсэн хариулт өгсөн байна. Уг асуултад хариулсан байдлаас харахад 50 орчим хувь нь 19 жилийн өмнөх энэхүү түүхэн үйл явцыг монголын түүхэнд цоо шинэ ул мөр гаргаж, нэг нийгмийн харилцааг өөр шинэ харилцаагаар халан өөрчилсөн “ардчилсан хувьсгал” байсан гэж дүгнэжээ. Харин бусад гэсэн сонголтыг сонгосон 8 хүн буюу 3,84% нь хөдөлгөөн байсан гэж хариулсан байна.

1990 оны ардчилсан хувьсгал өрнөх шалтгаан нь юу байсан гэж Та үзэж байна вэ? гэсэн асуултад тэд 1-3 хариултыг сонгож болохоор байсан бөгөөд тэдний 21,75% нь 1980 оны дунд үеэс ЗХУ-д өрнөсөн “Перестройка”-гийн нөлөөлөл, 21,10% нь социалист нийгмийн тогтолцоо үеэ өнгөрөөсөн явдал, 20,77% нь дэлхийн социалист системийн

задрал, 20,12% нь монголын нийгмийн улс төр, эдийн засгийн дотоод нөхцөл, 12,66% нь МАХН нийгмийг удирдах чадвараа алдсан явдал, 3,57% нь бусад шалтгаан байсан гэж хариулсан байна. Энэхүү асуултад хариулсан байдлаас харахад монголын 1990 оны ардчилсан хувьсгалд ЗХУ-д өрнөсөн “Перестойка”-гийн нөлөөлөл байсан гэж хариулсан нь хамгийн их хувийг эзэлж байна. Харин бусад гэсэн сонголтыг сонгогчид нь улс орны амьдрал маш аюултай байдалд хүрсэн, улс орны нийгэм, эдийн засгийн амьдрал улам доройтсон, улс орны хөгжилд саад бэрхшээл их байсан, дэлхийн хэмжээгээр явагдаж байсан үйл явц гэсэн шалтгаануудыг дурдсан байна.

Тухайн үеийн эрх баригч хүчин болох МАХН, түүний удирдлага, гишүүд, дэмжигчид 1990 оны ардчилсан хувьсгалд ямар байр сууринаас хандаж байсан бэ? гэсэн асуултад тэдний хариулсан байдлыг сонирхоход 27,88% нь эсэргүүцэж байсан ч хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байсан, 24,51% нь зарим хэсэг нь дэмжиж, зарим хэсэг нь эрс эсэргүүцэж байсан, 22,59% нь дэмжиж байсан, 14,42% нь эрс эсэргүүцэж байсан, 7,69% нь мэдэхгүй байна, 2,88% нь хүнд асуулт байна гэжээ. Уг асуултад хариулсан байдлаас үзэхэд зургаан хүн асуултыг хүнд, арванзургаан хүн энэхүү хувьсгалд тухайн үедээ МАХН, түүний удирдлага, гишүүд, дэмжигчид ямар байр сууринаас хандаж байсныг мэдэхгүй, гучин хүн эрс эсэргүүцэж байсан хэмээн тус тус хариулжээ. Харин үлдсэн нь МАХН, түүний удирдлага, гишүүд, дэмжигчид хүлээцтэй хандаж, дэмжиж, хүлээн зөвшөөрч байсан гэсэн байна.

Монголд ардчилсан хувьсгал ялах нь зайлшгүй үйл явц байсан уу? гэсэн асуултад 90,38% нь тийм, 9,61% нь үгүй гэж хариулсанаас үзвэл Монголын ард түмэн “шинэ” төрийг хүсч байсан учраас энэхүү 1990 оны ардчилсан хувьсгал нь зайлшгүй үйл явц байв.

Зайлшгүй үйл явц байсан бол тэр нь ямар нөхцөл байдлаас үүдэлтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултад 29,32% нь нэг намын дарангуйллыг хязгаарлах, 24,03% нь ард түмэнд эрх, эрх чөлөөг олгох, 17,78% нь хөгжлийн мухардмал байдлаас гарах, 13,46% гадаад олон улстай харилцах шаардлагатай байсан учраас, 10,57% нь бусад, 4,80% нь ЗХУ задарсан учраас гэж хариулсан байна. Уг асуултад хариулсан байдлаас харахад энэ үеийн цорын ганц МАХН-аас төр, засгийн үйл ажиллагааг шууд гардан чиглүүлэх замаар нөлөө үзүүлдэг байсан явдлыг зайлшгүй хүчин зүйл хэмээн олонх нь тэргүүн зэрэгт сонгосон байна. Хамрагдагчдын ийнхүү хариулсан нь тухайн үедээ МоАХ-ны Ерөнхий зохицуулагч С.Зоригийн “...хамгийн гол нь нэг намын ноёрхлыг халах, олон намын системд шилжих, жинхэнэ ардын засаглалыг тогтоох юм. ...Ер нь бид намын эсрэг хүмүүс биш ээ. Намын гишүүд бол үнэнч, шударга, сайн хүмүүс юм. Харин бид намыг завхруулсан хүмүүсийн эсрэг, засгийн эрхийг монополичилсон бүлгийн эсрэг байгаа юм” [1.38, 39] хэмээн хэлж байсантай утга дүйж байна.

Түүнчлэн энэхүү зайлшгүй үйл явц нь намын дотоод ардчиллыг бий болгох, бодит амьдралыг байгаа байдлаар нь танин мэдэж, нэгтгэн дүгнэх, үнэн байдлыг ил тод хэлж, шүүн ярилцаж, зөрчлийг шийдвэрлэж байх зэрэг бусад нөхцөл байдлаас үүдэлтэй байна гэжээ.

Монголын 1990 оны ардчилсан хувьсгалын удирдагчид өмнөө ямар зорилго тавьж байсан гэж Та үздэг вэ? 39,90% нь ард олныхоо амьдралыг өөрчилж, сайн сайханд хүргэх, 23,55% нь улс төрийн өөрчлөлтүүдийг хийх, 10,57% нь хэлж мэдэхгүй байна, 8,65% нь засгийн эрхэнд гарах зорилготой байсан, 5,76% нь нэг орны хараат байдлаас гарах эрмэлзэлтэй байсан, 5,28% нь зорилгогүй, бүх зүйл ямар ч төлөвлөлтгүй явагдсан, 3,84% нь зөвхөн МАХН-ын Улс төрийн Товчоог огцруулах зорилготой байсан, 2,40% нь зорилго нь тодорхойгүй, урсгалаар явж байсан гэжээ. Энэхүү асуултад хариулсан байдлаас харахад тэдний 18,25% нь ардчилсан хувьсгалын удирдагчдын зорилгыг хэлж мэдэхгүй байна, мөн тодорхой зорилгогүй байсан гэжээ. Түүнчлэн 64 орчим хувь нь ард олныхоо амьдралыг өөрчилж, сайн сайханд хүргэхийн зэрэгцээ “...улс төрийн системд жинхэнэ өөрчлөлт хийх явдал...” [1.38] гэсэн байна. 1990 оны ардчилсан хувьсгалын

удирдагчид “Монголын Ардчилсан Холбооны зорилго бол ард түмнийхээ язгуур эрх ашигт үнэнч байж, түүнийхээ төлөө цуцалтгүй тэмцэх, хүн ард энх амгалан аж төрөн хөдөлмөрлөж, аж амьдралаа хэлбэрэлтгүй дээшлүүлэх, үндэстэн ястны эв нэгдлийг эрхэмлэх, хүний эрхийг төгс баталгаажуулах, шударга ариун ёст ардчилал тогтоох” [2.6], өөрөөр хэлбэл, нийгэм, улс төр, эдийн засгийн байдал, цаг үеийн тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэхийг зорьсон.

Зарим иргэд 1990 оны ардчилсан хувьсгал гарахад гадны нөлөөлөл байсан гэдэг. Энэ тал дээр Та санал нэгдэх үү? гэхэд 40,86% нь мэдэхгүй, 40,38% нь нэгдэнэ, 18,75% нь нэгдэхгүй гэжээ. Ийнхүү хариулсан хамрагдагчид мэдэхгүй болон нэгдэнэ гэсэн сонголтыг сонгохдоо зарим нь гадны санхүүгийн дэмжлэгтэй хийсэн, бусдын зааварчлагын дагуу хийсэн зэрэг санааг нэмж бичсэн байлаа.

Хэрэв гадны нөлөөлөл байсан гэж үзэж буй бол Та юуг нөлөөлсөн гэж үздэг вэ? гэсэн асуултад 32,21% нь социалист системийн задрал, 19,71% нь хүнд асуулт байна, 16,82% нь өрнөдийн орнууд дахь ардчиллын хөгжилт, бэхжилт, 14,42% нь ЗХУ-д өрнөсөн “Перестройка”, 9,61% нь Монголын талаар явуулж байсан Хятад, Зөвлөлт 2 улсын бодлого, 7,21% нь бусад гэж хариулжээ. Энэхүү асуултад хариулсан байдлаас харахад монголын 1990 оны ардчилсан хувьсгалд гол нөлөөлсөн гадаад хүчин зүйл нь социалист системийн задрал хийгээд ЗХУ-д өрнөсөн “Перестройка”, өрнөдийн орнууд дахь ардчиллын хөгжилт, бэхжилт гэсэн байна. Мөн уг санал асуулгын бусад асуултуудаас хамгийн олон хүн буюу 41 нь энэхүү асуултыг хүнд асуулт байна гэжээ.

Монголд өрнөсөн ардчилсан хувьсгалын хамгийн чухал ололт Таны хувьд юу вэ? гэсэн асуултад тэд 1-3 хариултыг сонгож болохоор байсан бөгөөд тэдний 26,79% нь иргэд хувийн өмчтэй болсон, 19,38% нь олон хэвшил бүхий зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн, 10,45% нь ардчилсан төрийн тогтолцоог бэхжүүлсэн, 10,02% нь олон намын тогтолцоо бий болж, ардчилсан чөлөөт сонгуулиар төрөө байгуулдаг болсон, 10,02% нь иргэд гадаад орон руу чөлөөтэй зорчдог болсон, 8,06% нь дэлхийд Монгол улс нээлттэй болсон, 7,40% нь хүний эрх, эрх чөлөөг бодит утгаар нь баталгаажуулсан, 6,31% нь түүхэндээ анх удаа ардчилсан Үндсэн Хуультай болсон, 1,52% бусад гэж хариулжээ. Энэхүү асуултад хариулсан байдлаас үзэхэд монгол орныг ардчилал болоод зах зээлийн харилцаанд нэгэн зэрэг амжилттай шилжсэн гэдэгтэй хамрагдагчид санал нийлж байгаа нь харагдаж байна.

Үүнээс гадна тэд энэ хугацаан дахь ардчилсан хувьсгалын ололт хийгээд дутагдлыг дурдсан байна. Үүнд:

Нэг: Ололттой талууд:

- Олон түмэн үзэл бодол, итгэл үнэмшлээ чөлөөтэй илэрхийлдэг болсон;
- Хүний эрх, эрх чөлөөг тунхаглаж, бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн Үндсэн Хуультай болсон;
- Чөлөөт бүх нийтийн сонгуулиар УИХ, Ерөнхийлөгч, орон нутгийн ИТХ-ыг сонгодог болсон;
- Олон намын тогтолцоо бий болж, улс төрийн намууд эрх тэгш, чөлөөтэй, шударгаар өрсөлдөх боломжийг бүрүүлсэн;
- Улс төрийн системийн хувьд харьцуулашгүй өөрчлөлтүүд гарч, нийгмийн цаашдын хөгжлийн үндэс суурь бүрэлдэн тогтсон;
- Ард олон болоод намууд хоорондоо чөлөөтэй, идэвхтэй эвлэлдэн нэгдэх болсон;
- Монголчууд өөрийн гэсэн өмч хөрөнгөтөй болсон гэх мэт.

Хоёр: Дутагдалууд:

- Шударга ёс бүгдэд хүртээмжтэй бус байна;
- Улс оронд гүйцэтгэх намуудын үүрэг сул байна;
- Парламент сонгуулиа хийж чадахаа больсон. /Сүүлийн хоёр сонгуулиас харахад /2004, 2008он/ сонгууль явагдаад хэдэн сар өнгөрсөн ч 76 гишүүнтэй байх ёстой УИХ бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллахгүй байдаг жишээг энд хэлж байна/;

II. МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

- Эрх баригчид зүй бусаар эрх мэдлээ хэтрүүлж байна;
- Эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байна гэх мэт дутагдал байна гэжээ.

Монгол дахь ардчилсан үйл явцад дүн тавибал Та ямар дүн тавих вэ? гэсэн асуултад 43,26% нь дунд, 33,65% нь сайн, 10,57% нь муу, 7,21% нь мэдэхгүй байна, 5,28% нь онц гэж хариулжээ. Эндээс харахад энэхүү ардчилсан хувьсгалд хамрагдагчид өөр өөр үнэлэлт өгсөн байна. Тэдний тэн хагасаас илүү нь монгол дахь ардчилсан үйл явцыг сайнаар үнэлж, арван хувь нь сөрөг үнэлж, долоон хувь нь үүнд үнэлэлт өгч чадсангүй.

Таны хувьд Монголд өрнөсөн ардчилсан хувьсгал зорьж байсан зорилго, үр дүндээ хүрсэн гэж та үзэж байна уу? гэсэн асуултад 42,30% нь зарим талаар хүрсэн, 27,40% нь хүрээгүй, 14,90% нь зорьж байсан зорилгоосоо өөр үр дүнд хүрсэн, 9,61% нь хүрсэн, 5,76% нь хариулахад хэцүү байна гэж хариулжээ. Энэхүү асуултад хариулсан байдлаас харахад 66,81% нь монголд өрнөсөн ардчилсан хувьсгал зорьж байсан зорилгодоо ямар нэгэн хэмжээгээр хүрсэн гэж үзсэн байхад 27,40% нь зорилгодоо бүрэн хүрч чадаагүй гэжээ.

Эцэст нь дүгнэхэд 1990 оны уг түүхэн үйл явц нь монголын нийгмийн дэвшил байсан учраас яахын аргагүй ХУВЬСГАЛ мөн бөгөөд энэхүү ардчилсан хувьсгал нь зорилгоо биелүүлж чадсан юм. Монголын 1990 оны Ардчилсан хувьсгалд ЗХУ-д өрнөсөн “Перестройка” хийгээд социалист системийн задрал зохих нөлөө үзүүлсэн байна.

Энэхүү санал асуулгад хамрагдагчид Монголын 1990 оны Ардчилсан хувьсгалын талаар өмнө нь санал бодлоо өгч байгаагүйгээ хэлэхийн ялдамд тэдний санал бодлыг авч байгаад ихэд талархан, судалгаанд идэвхтэй сайн оролцсон юм. Тэд уг асуулгыг ойлгомжтой хэдий ч зарим нэгэн санаа, асуултууд давхцаж байгааг цаашдын ажилдаа анхааран ажиллахыг хүсэмжилж байсныг санаж, тэрхүү давхцалыг арилгахыг хичээж нэгтгэн дүгнэлээ.

Abstract:

This opinion poll was conducted for the purpose of drawing a conclusion on the basis of studying public opinion about Mongolian Democratic Revolution 1990. New social phenomena which had been occurred throughout Soviet Union since mid of 1980, was Perestroika. It had exerted a certain influence on Mongolian Democratic Revolution.

• Ашигласан ном зохиол:

1. Ж.Заанхүү. 1990 оны ардчилсан хөдөлгөөний түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ., 2004.
2. МоАХ-ны анхдугаар Их хурал. 1990-02-18. УБ., 1990.
3. Намын амьдрал сэтгүүл. II сар. УБ., 1990.
4. Октябрын туяа сэтгүүл. II сар. УБ., 1990.
5. С.Төмөр-Очир. Социологийн судалгааны арга, техникийн дадлага. УБ., 2003.